

“/\_\_\_\_\_ /” ИРГЭН

“/\_\_\_\_\_ /” ИРГЭН

хоорондын

## **ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ**

## ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ

20-- оны...сарын.....өдөр

Улаанбаатар хот

Энэхүү зээлийн гэрээ /цаашид “Гэрээ” гэх/-г Монгол Улсын иргэний хуулийн 281-285 дугаар зүйл, Зээлдэгчийн хүсэлтийг тус тус үндэслэн нэг талаас иргэн \_\_\_\_\_овогтой...../ Регистр.....цаашид “Зээлдэгч” гэх/, нөгөө талаас иргэн \_\_\_\_\_овогтой \_\_\_\_\_ цаашид “Зээлдүүлэгч” хамтад нь “Талууд” гэх/ нар дор дурдсан нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Гэрээгээр нэг талаас Зээлдүүлэгчээс Зээлдэгчид тодорхой хугацаа, хүүтэйгээр зээл олгох, түүнийг эргүүлэн төлүүлэх үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцаа; нөгөө талаас Зээлдэгч Зээлдүүлэгчээс тодорхой хугацаа, хүүтэйгээр зээл авах, түүнийг эргүүлэн төлөх, гэрээний үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулж үл хөдлөх хөрөнгө барьцаалуулах үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг тус тус зохицуулна.

1.2. Нэг талаас Зээлдэгч нь зээлийг энэхүү Гэрээнд заасан хэмжээ, нөхцөлөөр авах, нөгөө талаас Зээлдүүлэгч нь гэрээнд заасан нөхцөлөөр зээл олгохоор харилцан хүсэл зоригоо илэрхийлсний үндсэн дээр Гэрээнд заасан зээл, зээлийн хүү, анзын дор дурдсан нөхцөлүүдийг харилцан тохиролцов.

### ХОЁР. ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ, ХҮҮ

2.1. Гэрээгээр Зээлдэгч нь Зээлдүүлэгчид \_\_\_\_\_ төгрөгийн зээл олгож байгаа болно.

2.2. Зээлийн хүү нь нэг сард \_\_\_\_\_ хувь буюу \_\_\_\_\_ төгрөг байна.

### ГУРАВ. ЗЭЭЛИЙН ХУГАЦАА

3.1. Зээлийн хугацаа нь / \_\_\_\_\_ / сар болно.

3.2. Гэрээний 3.1-д заасан хугацааг талууд хэлэлцэн тохиролцож сунгаж болно.

### ДӨРӨВ. ГЭРЭЭНИЙ НУУЦЛАЛ

4.1. Аль нэг Тал компанийн бизнес төлөвлөгөө болон энэ гэрээний дагуу мэдэх болсон бусад Талуудын бизнесийн нууцлалыг чандлан хадгалах бөгөөд нууцлал задруулбал энэ гэрээний 6 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

### ТАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

#### 5.1. Зээлдэгчийн эрх, үүрэг:

5.1.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Зээлдүүлэгчээс шаардах эрхтэй;

Зээлдэгч тал

Зээлдүүлэгч тал

5.1.2. Гэрээнд заасан хугацаанд зээлийг хүүгийн хамт Зээлдүүлэгчид эргүүлэн төлнө;

5.1.3. Зээлдэгч зээлийн бичиг баримтыг хуурамчаар бүрдүүлсэн, мөн энэхүү гэрээний заалтуудыг зөрчсөнөөс болж Зээлдүүлэгчид учирсан аливаа хохирол, зардлыг Монгол Улсын Иргэний хуулийн дагуу зээл, түүний хүүг төлсөн эсэхийг үл харгалзан төлж барагдуулна;

5.1.4. Зээлдэгч зээлийг гэрээний 3.1-д заасан хугацаанд бүрэн төлөөгүй тохиолдолд гэрээнд заасан хариуцлагыг хүлээнэ.

## **5.2. Зээлдүүлэгчийн эрх, үүрэг:**

5.2.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Зээлдэгчээс шаардах;

5.2.2. Гэрээний 3.1-д заасан хугацаа дуусахад Зээлдэгч зээлийн төлбөрийг хүүгийн хамт бүрэн төлж барагдуулаагүй хугацаа хэтрүүлсэн тохиолдолд Зээлдэгчийн барьцаалуулсан барьцаа хөрөнгийг үл маргах журмаар худалдан борлуулж зээл, зээлийн хүү, анзыг тооцон авах;

5.2.3. Зээлдэгч зээл, зээлийн хүүг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд Зээлдүүлэгч гуравдагч этгээдэд зээлийн өрийг худалдах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх зэрэг хуулиар хориглогдоогүй бүхий аргаар зээлийг төлүүлэх арга хэмжээ авах;

5.1.4. Гэрээний 4 дүгээр зүйлд заасан эд хөрөнгийг гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар барьцаалуулсан бөгөөд Монгол Улсын Иргэний хуульд заасан барьцаалуулагчийн эрхийг эдэлж, үүргийг хүлээх.

## **ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА**

6.1. Зээлдэгч нь хүлээсэн үүргээ гэрээнд заасан хугацаанд биелүүлээгүй тохиолдолд учирсан бүхий л хохирол, зардлыг нөхөн төлнө.

6.2. Зээлдэгч нь зээл болон хүүг гэрээнд заасан хугацаанд нь төлөх үүргээ биелүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувийн алданги төлнө.

## **ДОЛОО. БУСАД ЗҮЙЛ**

7.1. Гэрээнээс үүдэлтэй аливаа маргаан гарвал Талууд хэлэлцээний замаар шийдвэрлэх боломжит бүхий л арга хэмжээг авна. Хэрэв уг арга хэмжээ нь зохих үр дүнд хүрэхгүй бол хуульд заасны дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

7.2. Гэрээнд талууд тохиролцон нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

7.3. Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэх бөгөөд эхүүд нь нэгэн адил хүчинтэй байна.

7.4. Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурж, нотариатаар гэрчлүүлж, эрхийн улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

## **НАЙМ . ТАЛУУДЫН ХУУЛЬ ЁСНЫ ХАЯГ**

### **Зээлдэгч:**

Хаяг: \_\_\_\_\_

Утасны дугаар: \_\_\_\_\_

Дансны дугаар: \_\_\_\_\_

### **Зээлдүүлэгч:**

Хаяг: \_\_\_\_\_

Утасны дугаар: \_\_\_\_\_

Дансны дугаар: \_\_\_\_\_

## **ЕС.МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ**

9.1. Энэхүү гэрээтэй холбогдон гарах аливаа санал зөрөлдөөн, маргааныг Талууд харилцан зөвшилцөх журмаар шийдвэрлэнэ. Харилцан зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд уг асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монголын Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ

## **АРАВ.ГЭНЭТИЙН БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ**

10.1. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлсийн улмаас аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний үүргээ биелүүлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилах хүртэл хойшлуулна.

10.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлс 60 хоногоос дээш хугацаагаар үргэлжилсэн, хэдийд дуусах нь тодорхойгүй тохиолдолд талууд харилцан тохиролцож гэрээг дуусгавар болгох эрхтэй.

## **ГЭРЭЭ БАЙГУУЛСАН :**

Зээлдүүлэгч: .....

Зээлдэгч: .....

Зээлдэгч тал

Зээлдүүлэгч тал

\_\_\_\_\_

\_\_\_\_\_